

Хүний эрхийн нөлөөллийн чиглэл

1. Хүний эрхийн үндэсний бүтэц механизмыг бэхжүүлэхэд дэмжих зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комиссын хараат бус үйл ажиллагаа, санхүүжилтийг Парисын зарчимд нийцүүлэн жил бүр хийдэг үнэлгээг 13 жил тасралтгүй үргэлжлүүлэн хийж, дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлсэн.
2. НҮБ-ын Хүний эрхийн хороо, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн хороо, Хүний эрхийн зөвлөлийн Тогтмол түгээмэл хэлэлцүүлэгт зориулж хүний эрхийг хамгаалах үндэсний бүтэц механизм, эрх зүйн орчин, ядуурал, хүнсний эрх, байгаль орчны хэргийг шүүхээр шийдвэрлэж байгаа асуудал зэргээр дангаар болон бусад байгууллагуудтай хамтран илтгэл бичиж, хэрэгжилтийг хянаж байна.
3. Хүний эрх хамгаалагчдын Үндэсний зөвлөгөөнийг 2015-2018, 2023-2024 онуудад нийт 6 удаа зохион байгуулж Улаанбаатар хот болон орон нутгаас нийт 400 орчим хүний эрх хамгаалагчдыг оролцуулан үйл ажиллагааны нэгдсэн стратегитай болох, харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг ажлыг хийж байна.
4. Ахмад настны хүний эрхийн хэрэгжилтээр үнэлгээ хийх, хэлэлцүүлэг зохион байгуулах, ахмад настны хүний эрхийн конвенцийн агуулга боловсруулах НҮБ-ын Нээлттэй ажлын хэсгийн хуралдаанд оролцох, үндэсний бодлого боловсруулахад ахмад настны эрхийн хэрэгжилтийг сайжруулахад чиглүүлэх зорилготой оролцож байна.
5. Хүний эрхийн олон улсын өдрийг иргэд мэддэг болох, тэмдэглэдэг болох, асуудлаа ярьдаг болох уламжлалыг тогтоох зорилготой Хүний эрхийн олон улсын өдрийг тэмдэглэх санаачлага гарган хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум, орон нутагт байгаа ХЭХТ-ийн харьяа Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн холбоодтой хамтарч ажиллаж байна. Нээлттэй цуглааныг 2015 оноос эхлэн “Хүний эрх хамгаалагчдыг хамгаалъя”, “Оролцооны эрхийг баталгаажуулъя”, “Хүний эрхийн асуудлыг Тогтвортой хөгжлийн зорилгуудад тусган шийдвэрлэе” “Хүний эрхийн ТББ-дын нээлттэй өдөрлөг” зэрэг сэдвээр зохион байгуулсан. Улмаар энэ санаачлагыг Хүний эрхийн форумын гишүүд үргэлждүүлэн хэрэгжүүлдэг болж улам өргөжиж байна.
6. Монгол улсыг хүний эрхэд суурилсан хөгжлийн бодлоготой болгох, хүний эрхийн тулгамдсан асуудлуудад төрийн бодлогыг чиглүүлэх, хүний эрхэд суурилсан бодлого боловсруулахад мэдээлэл өгөх зорилгоор 2016-2018 онуудад улс төрийн намуудтай уулзалт зохион байгуулан хүний эрхийн форумын гишүүд, орон нутгийн хүний эрх хамгаалагчдыг оролцуулж байна. Түүнчлэн 2020, 2024 оны сонгуулийн өмнө хүний эрхийн тулгамдсан асуудлыг бодлогод тусган хэрэгжүүлэх байр суурийн баримт бичгийг улс төрийн намуудад

хүргүүлэх ажлыг Хүний эрхийн форум, “Тогтвортой хөгжлийн төлөөх ИНБ” Сүлжээний нэрийн өмнөөс зохион байгуулсан байна.

7. Орон нутгийн иргэдийг тулгамдсан асуудлаа хуулийн хүрээнд тайван замаар өргөн хүрээний оролцоотойгоор шийдүүлдэг болох чадавхи бий болгох, жишиг тогтооход анхаарч ажиллаж байна. Үүний жишээ нь Дорнод аймгийн 11 сумын 3000 гаруй иргэдийн оролцоотойгоор 13 нэр бүхий экологийн үнэ цэнэтэй газрыг улсын тусгай хамгаалалтанд авахуулах аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр гаргуулах нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 6 сумын 9 нэр бүхий газрыг улсын тусгай хамгаалалтад авах шийдвэр гаргуулсан.
8. Газар нутгийг тусгай хамгаалалтанд авах, байгалийн нөөцийн менежментийг зохион байгуулахад иргэдийн оролцоог хангах чадавхи бэхжүүлэх хүний эрх, эрх зүйн сургалтууд хийж нийт 6 аймгийн 67 сумын 2700 малчдыг хамруулсан.
9. Дорнод аймгийн Дашбалбар сум, Дорноговь аймгийн Улаанбадрах суманд байгаль орчны шударга ёс болон уурхайн компани, орон нутгийн захиргааны хооронд байгуулсан хамтын гэрээний хэрэгжилтийг хянах орон нутгийн иргэдийн мэдлэг мэдээллийг сайжруулах, чадавхи бэхжүүлэх сургалт, судалгааг орон нутгийн иргэдийн оролцоотой хийсэн.
10. Гадаадын зээл тусламж болон иргэний нийгмийн байгууллагын хөгжлийн үр нөлөөг сайжруулах Хөгжлийн хамтын ажиллагааны дэлхийн түншлэлийн хүрээнд хийдэг хоёр дох удаагийн мониторингд оролцон иргэний нийгмийн оролцооны орчин, түүнийг төрийн болон олон улсын хөгжлийн байгууллагууд хэрхэн институтчилсан байдал зэргээр мэдээлэл цуглуулах, үнэлэх, хэлэлцүүлэг хийх зэрэг ажил хийж байна.
11. Орлого багатай иргэдийн давхардсан тоогоор 8560 гаруй өрх, 15458 иргэдийн орон байр, амьдрах орчинг сайжруулж, 60 гаруй өрхөд орон байраа сайжруулах буцалтгүй тусламж үзүүлсэн.
12. Оролцооны эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр гарч байгаа хууль, эрх зүйн акт, бодлого, хөтөлбөртэй тогтмол танилцуулах, хэрэглэх чадавхи бий болгох зорилготой сургалтуудыг хийж байна.

Хамтран болон удирдан ажилласан бүтээлийн жагсаалт

1. Нийгмийн хамгааллын асуудлууд. Эмэгтэйчүүдийн мэдээлэл судалгааны төв (ЭМСТ), Улаанбаатар, 1996
2. Шилжилтийн үеийн Монголын эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдал. ЭМСТ, Улаанбаатар, 1998

3. Бэлгийн замын халдварт өвчин, ДОХВ/ДОХ тухай мэдлэг, хандлага, дадлын тухай эрсдэлт бүлгийн дунд хийсэн судалгаа. 1998
4. Эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх төслийн үнэлгээ. ЭМСТ, 1998
5. Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хэрэгцээ шаардлага. ЭМСТ, 1998
6. Эмэгтэйчүүдийн жижиг зээлийн хүртээмж. ЭМСТ, Улаанбаатар, 1999
7. Монгол дахь жендэрийн асуудлууд. 2000
8. Эмзэг бүлгийн хүний эрхийн байдал. Хүний эрх хөгжил төв (ХЭХТ), 2001
9. Монгол дахь эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүний наймааны гэмт хэрэг. ХЭХТ, 2002
10. Монгол дахь зохистой орон байрны эрхийн хэрэгжилт. ХЭХТ, 2003
11. Ноолуурын секторын нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ. ХЭХТ, 2003
12. Таны эдлэх эрх. ХЭХТ, 2004
13. Улаанбаатар хотын ядуучуудын иргэний бүртгэл ба нийгмийн хамгааллын эрх. ХЭХТ, 2004
14. Монголд хүний наймааны хэрэгтэй тэмцэх нь: асуудлууд ба боломжууд. ХЭХТ, 2005
15. Улаанбаатар хотын ядуучуудын оролцооны үнэлгээ. ХЭХТ, 2005
16. Уул уурхайгаас байгаль орчин, нутгийн иргэдэд үзүүлж байгаа нөлөөлөл ба холбогдох эрх зүйн зохицуулалтуудын үр нөлөөний үнэлгээнүүд. ХЭХТ, 2005-2015
17. Хүний эрхийн Үндэсний Комиссын Гүцэтгэлийн Мониторингийн илтгэлүүд (13 цуврал). ХЭХТ, 2008-2023.
18. Монгол дахь хүний эрхийн төлөв байдал. ХЭХТ 2010, 2015, 2020, 2025
19. Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт. Монголын Иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан илтгэл 2019, 2023
20. КОВИД – 19- ын Монголын иргэний орон зайд үзүүлсэн нөлөө. ХЭХТ, 2021
21. Монголын ардчиллын сорилтууд: Иргэний нийгмийн байгууллагууд өнцгөөс. ХЭХТ, 2023
22. Уур амьсгалын өөрчлөлтөөс цирсан хохирол, хор уршгийн тухай иргэд манлайлсан судалгааны тайлан. ХЭХТ, 2024